

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС
2018 ОНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

1. Төрийн албан хаагчын спортын анхдугаар их наадмыг Баян-Өнжүүл, Лүн, Угтаалцайдам, Эрдэнэ, Баянчандмань, Зуунмод гэсэн 6 бүсэд зохион байгуулж 4.098 хүнийг хамруулсан

Үр дүн: Төрийн албан хаагчдын спортоор хичээллэх идэвхийг өрнүүлж, их спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлсэн.



2. Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлаар үндэсний сурын талбай /69.5 сая/, шагайн харвааны асар (25мх30м) /269 сая/, софт теннисний талбай, /52.5 сая/, волейболын талбай /58.4 сая/, цэнгэлдэх хүрээлэн тойрсон гүйлт, алхалт, дугуйн зам /68.1 сая/, олон улсын хөл бөмбөгийн холбооны дэмжлэгээр /850.0 сая/ стандартын хөл бөмбөгийн талбай шинээр байгуулж ашиглалтанд оруулсан

Үр дүн. Үндэсний болон спортоор хичээллэгчдийн ая тухтай байдлыг хангаж материаллаг орчин нөхцөл сайжирч, хичээллэгсэд сонирхогчидын тоо өсч олон улсын болон улсын чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах нөхцөл боломжоор хангагдсан.



3. Аймгийн үндэсний спортын VI их наадмын хүрээнд үндэсний спортын 16 төрлөөр арга хэмжээ зохион байгуулж, 27 сумын 2373 хүн хамрагдаж, үндэсний спортын VI-р их наадмын шигшээ тэмцээнд 53 тамирчин оролцож Алт-7, Мөнгө-16, Хүрэл-19, бүгд-42 медаль хүртэж, спортын мастерын болзлыг 3, спортын дэд мастерын болзлыг 3 тамирчин ханган биелүүлж, байгууллагын нэгдсэн дүнгээр II-р байр эзэлж, цом өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдав.

Үр дүн: Үндэсний спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдэж, улсын хэмжээнд тэргүүлэх тамирчид төрөн гарсан.



2018 ОНЫ 12-Р САРД ХИЙГДСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-12-24


Зуунмод

Нэг. Зохион байгуулагдсан уралдаан тэмцээн

МУ-ын харьшгүй мэргэн Н.Төмөрбаатарын нэрэмжит ОТГО харвааг 2018.12.01-нд зохион байгуулж 41 багийн 328 тамирчин ороцлоо.



Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн уламжлалт тэмцээнийг 2018.12.04-нд зохион байгуулж 6 багийн 34 тамирчинд оролцлоо.



АБТА, БТТА, Волейболын спортын мастер С.Алтанхуягийн нэрэмжит өсвөр үеийн ААШ волейболын тэмцээнийг 2018.11-29-30-ны өдрүүдэд Батсүмбэр суманд А.Эрдэнэбат захиралтай ЕБС-тай хамтран зохион явуулж 32 багийн 256 тамирчин хамрагдан оролцлоо.



Монгол улсын их хурлын даргын ивээл дор шинэ үндсэн хууль батлагдсан өдөрт зориулан зохион байгуулсан шатар сонирхогчдын Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018-12-08 нд Аймгийн ИТХ ,БТСГ,Аймгийн шатрын холбоо хамтран амжилттай зохион явуулж 12 сумын 32 тамирчин хамруулсан.



УИХ-ын гишүүн, Батлан хамгааланы сайд Н.Энхболдын нэрэмжит “Атарчин-2018” спортын наадам 2018 оны 12-р сарын 15-16-нд зохион байгуулагдаж 24 сумын 220 гаруй тамирчид спортын 5 төрлөөр өрсөлдлөө.



2018 оны спортын шилдэгүүдийг шалгаруулах ёслолын ажиллагааг 2018.12.21-нд зохион байгуулж спортын 13 төрлөөр улсын аварга шалгаруулах тэмцээнд медаль байрт шалгарсан 130 тамирчинд мөнгөн урамшуулал олгож шилдэгүүдээ шалгарууллаа.



Оролцсон уралдаан тэмцээн.

УБ хотноо зохион байгуулагдсан Ази тивийн аварга шалгаруулах пауэрлифтингийн тэмцээн манай тамирчин Д.Төмөрчөдөр амжилттай оролцож хүхрэл медаль хүрлээ.



МУ-хөдөлмөрийн баатар Ш.Отгонбилэг агсаны нэрэмжит "ОЛИМПИЙН ОДОД" чөлөөт бөхийн тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож 1 алт, 3 хүрэл медаль хүртлээ.



Насанд хүрэгчдийн боксын УАШТ-нд манай баг тамирчид амжилттай оролцож Г.Ган-Эрдэнэ 52 кг-д хүрэл, Б.Цэндсүрэн 57 кг-д хүрэл медаль хүртлээ.

Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

2018 ОНЫ 11-Р САРД ХИЙГДСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-11-29

Зуунмод

Нэг. Сургалт семинар, зөвлөгөөн

Аймгийн Прокурорын газраас 3 хүний бүрэлдэхүүнтэй баг 2018.11 дүгээр сарын 28-нд гэр бүлийн хүчирхийлэл, авилгалын тухай хуулийг сурталчилах сургалтыг зохион байгуулж тус сургалтанд 20 ажилтнаас, 14 албан хаагч хамрагдсан. Үүнээс өвчтэй-2, гадаадад тэмцээнд-1, хөдөө сумруу-1, ирээгүй-2 ажилтан байна. Ирц 75%-тай байна.



Иргэний хамгааллын өндөржүүлсэн бэлэн байдлын сургалтын хүрээнд 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр албан байгууллагуудын дарга, сумдын засаг дарга нарын дунд сорилын тэмцээн зохион байгуулсан. Үүнд 10 багийн 91 хүн оролцож, 4 өртөөт даалгаврыг

гүйцэтгэж багийн нэгдсэн дүнгээр 1-р байрыг 10-р баг, 2-р байрыг 9 дүгээр баг, 3-р байрыг 8 дугаар багууд тус тус эзэллээ.



№	Байгууллагын нэр	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т
1	1-р БАГ	15	14	13	12	11	10	9	8	7
2	2-р БАГ	13	12	11	10	9	8	7	6	5
3	3-р БАГ	11	10	9	8	7	6	5	4	3
4	4-р БАГ	9	8	7	6	5	4	3	2	1
5	5-р БАГ	7	6	5	4	3	2	1	0	0
6	6-р БАГ	5	4	3	2	1	0	0	0	0
7	7-р БАГ	3	2	1	0	0	0	0	0	0
8	8-р БАГ	1	0	0	0	0	0	0	0	0
9	9-р БАГ	0	0	0	0	0	0	0	0	0
10	10-р БАГ	0	0	0	0	0	0	0	0	0

2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд Монголын Аутизмын холбоо, Дауны холбоо, Монголын Тусгай Олимпын хорооны сургагч багш, удирдах ажилтнуудын үйл ажиллагаа, өнөөгийн байдлын талаарх сургалтанд НБТ-ын арга зүйч Э.Сайнзаяа оролцлоо.



Зохион байгуулсан уралдаан тэмцээний талаар

Монгол бахархалын өдөрт зориулсан “Зуунмодны цом 2018” шаганй харвааны тэмцээнийг 2018 ны 11-р сарын 08-ны өдөр зохион байгуулж 15 багийн 105 харваачид оролцсон.



Мэргэшсэн нятлан бодогчтой байгууллагуудын дундах вролейболын тэмцээнийг 2018.11.24-нд зохион байгуулж 13 багийн 100 гару й тамирчид хамрагдлаа.



Оролцсон уралдаан тэмцээний талаар:

Булган аймагт зохион байгуулагдсан бага насны улсын аварга шалгаруулах боксын тэмцээнд 49 байгууллагын 420 гаруй тамирчид оролцсоноос манай баг тамирчид амжилттай оролцож 1 алт, 1 мөнгөн медаль хүртлээ



ӨМӨЗО-ны Шилийн хотод болсон өсвөр үе залуучуудын ОУ-ын тэмцээнд Төв аймгийн баг тамирчид амжилттай оролцон 1 алт(60 кг Л.Билгүүн) 1мөнгө (125 кг Э.Эрхэмжаргал) 3 хүрэл (55кг Цэнгэл бадрах,76кг Батбилгүүн,80 кг Мөнхэрдэнэ) медаль хүртлээ.Мөн шилийн хотын шигшээ баг болон тауун хотын шигшээ багтай 14 хоногийн хамтарсан бэлтгэл хийлээ.



Солонгос улсад зохион байгуулагдсан өсвөр үеийн Дэлхийн аварга шалгаруулах софт теннисний тэмцээн 2018.11.55 -29-ны өдрүүдэ зохион байгуулагдаж манай аймгаас 7 тамирчин оролцож 5-р сургуулийн сурагч Б.Тулга хүрэл медаль хүртлээ

ОХУ-ын Якут хотод болсон масрислингийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 2018.11.22-25-нд зохион байгуулагдаж манай 3 тамирчин амжилттай оролцоод ирлээ.

Тайлан бичсэн

Нарийн бичиг

Л.Энхцэцэг

2018 ОНЫ 10-Р САРД ХИЙГДСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-10-28

Зуунмод

Нэг. Сургалт семинар, зөвлөгөөн

Таны эрүүл мэнд- Таны гарт аяны хүрээнд “Цэвэр гар эрүүл амьдралын жор” сэдвийн дор Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн сурагчдаар гар угаах зөв хэвшлийг сургах зорилгоор сургагч баг нараар байгууллага дээрээ 2018.10.11-ны өдөр хичээл заалган БТСГ-ын 8 хүн, үндэсний бөхийн өсвөр үе, залуучууд, насад хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор бэлтгэл сургуулилт хийж буй тамирчид 6 нийт 14 хүн сургалтанд хамрагдан гарын авлаг тараах материалыг өгсөн.



БСШУСЯ, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ хамтран МУ-ын ерөнхий сайдын ивээл дор “СПОРТ БА ХӨГЖИЛ” биеийн тамирын удсын 4-р зөвлөгөөнийг 2018.10.18-19-нд УБ хот төрийн ордонд зохион байгуулж энэхүү зөвлөгөөнд Төв аймгаас 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцсон



Хоёр. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

1. МУ-ын ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан Иргэдийн спортын их наадмын шигшээ тэмцээнийг 2018 оны 10-р сарын 06-нд зохион байгуулж 13 сумын эр 27, эм 17 нийт 44 багийн 374 тамирчин оролцож спортын 3-н төрлөөр өрсөлдлөө.



Төв аймгийн залуус ТББ-тай хамтран явган аялалын тэмцээнийг зохион байгуулж 6 багийн 68 аялагчид оролцож 3 төрлийн тэмцээн зохион байгуулагдаж нийлбэр дүнгээр Н.Хорлоо ахлагчтай Олс баг тэргүүн байрыг эзэлсэн



Төв аймгийн Зуунмод түгээх төвийн ажилчдын дундах уламжлалт тэмцээн 2018 оны 10-р сарын 10-ны өдөр зохион байгуулагдаж 5 багийн 40 гаруй албан хаагчид оролцож спортын 5 төрлөөр өрсөлдөж аваргуудаа тодрууллаа.



2. Төв аймгийн ахмадын хорооны 30 жилийн ойн баярыг тохиолдуулан 2018.10.24-ны өдөр 5 багийн ахмадуудын дунд софтволейбол, ширээний теннисний тэмцээн амжилттай зохион байгуулагдаж 5 багийн нийт 53 ахмад оролцлоо.

1-р байранд - Номт баг

2-р байранд – Ланс баг

3-р байранд – 6-р баг байр эзэлж тус тус медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал хүртлээ.



Гурав. Оролцсон уралдаан тэмцээний талаар

Уулын болон уралдааны дугуйн хаалтын тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож 5 алт, 6 мөнгө, 4 хүрэл медаль хүртлээ.

Дөрөв. Онцлох ажил:

БСШУСЯ, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ хамтран МУ-ын ерөнхий сайдын ивээл дор “СПОРТ БА ХӨГЖИЛ” биеийн тамирын удсын 4-р зөвлөгөөнийг 2018.10.18-19-нд УБ хот төрийн ордонд зохион байгуулж энэхүү зөвлөгөөнд Төв аймгаас 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцсон



2018 ОНЫ 09-Р САРД ХИЙГДСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-09-28

Зуунмод

Нэг. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын ЗДТГ- аймгийн шагайн товчоотой хамтран Сөдөтын тойрмыг 2018.09.08-09-ны өдрүүдэд Баян-Өнжүүл суманд зохион байгуулж 25 багийн 200 гаруй харваачид хамрагдсан.



GOOD NEIGHBORS-MONGOLIA КРОСС ГҮЙЛТИЙН УАШТ-ийг 2018.09.15-16-ны өдрүүдэд Зуунмод суманд зохион явуулж 31 байгууллагын 377 тамирчин оролцож манай аймгийн баг тамирчид багийн дүнгээр 1-р байр эзэлж 4 алт, 3 мөнгө, 6 хүрэл медаль хүртлээ.



9-р сард НЭМ-ийн өдрийн хүрээнд зохион байгуулагдсан нарын алхалтыг 4 удаа зохион байгуулж 76 байгууллагын 630 албан хаагчид хамрагдсан.



Үндэсний бөхийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018.09.29-30-нд Эрдэнэсант суманд зохион явуулж 8 сумын 72 тамирчин оролцлоо.



Ахмадын баярыг угтаж Зуунмод сумын 6-н багийн ахмадуудын дунд граунд гольфийн тэмцээнийг 2018-09-29-нд зохион байгуулж 6 багийн 28 ахмад хамрагдлаа.



Нисэх онгоцны буудлын ажилчдын Алтан намар 2018 тэмцээн 2018.09.29-нд зохион байнгуулагдаж 9 багийн 198 хүн спортын 5 төрлөөр өрсөлдлөө.



Хоёр. Оролцсон уралдаан тэмцээн

Төв аймгийн харьяат МУ-ын гавьяат тамирчин Д.Намжилмаагийн нэрэмжит ахмад мастеруудын хөнгөн атлетикийн УАШТ 2018.09.19-20-нд УБ хотноо зохион явагдаж манай аймгаас 8 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид амжилттай оролцлоо.

ӨМӨЗОрны Ордос хотноо зохиогдож буй Монгол туурагтан хүүхдийн наадамд байт харвааны тамирчид маань амжилттай оролцож байна. Охидын баг хүрэл медаль, О. Анужин холимог багийн харваанд Мөнгөн медаль хүртлээ.



Гурав. Сургалт, семинарт оролцсон тухай

“Өртөөт Марафон” гүйлтийн арга зүйч нарын сургалт семинар 2018.09.20-22-нд УБ хотод зохион байгуулагдаж 21 аймаг 9 дүүргийн 39 арга зүйчид хамрагдсанаас манай 4 арга зүйч оролцож марафоны үүсэл хөгжил, шүүгчийн ёс зүйн талаар хичээл заалгаж “Үзэсгэлэнт Улаанбаатар” марафон гүйлтийн тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүнд ажилласан.



Дугуйн дасгалжуулагч Г.Батсүх, тамирчид О.Одбилэг нар БНСУ-д зохион байгуулагдсан өсвөрийн тамирчдын бэлтгэл сургуулилт, тэмцээн уралдаанд оролцох талаарх сургалтанд хамрагдсан



Мэдээг нэгтгэсэн
Нарийн бичиг Д.Энхцэцэг

2018 ОНЫ 08-Р САРД ХИЙГДСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-08-30

Зуунмод

Нэг. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

1.Зүүн хойд Азийн бүс нутгийн хурлын дарга нарын 9 дэх удаагийн форумд зориулсан бэсрэг наадмыг 2018 оны 08-р сарын 02 нд Эрдэнэ сумын нутагт зохион байгууллаа. Наадамд зориулсан үндэсний сурын харваанд:



2. ‘Үндэсний цом-2018’ 21 аймгийн хөлбөмбөгийн Улсын аварга шалгаруулах тэмцээн нь ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр зохион байгуулагддаг. Энэхүү тэмцээн нь 2018.08.17-25ны өдрүүдэд Зуунмод хотноо зохион байгуулагдсан.Тус тэмцээнд: 16 аймгийн

1.Увс аймаг 1- байр

2.Орхон-2 байр

3.Төв аймгийн хөлбөмбөгийн шигшээ баг 3-р байр эзлэж, амжилттай оролцлоо.



3.2018.08.24-нд Зуунмод хотноо Champions Cup Tuv Aimag-2018 хүчний /мод таталтын / төрлийн нээлттэй тэмцээн болж эрэгтэй, эмэгтэй нийт 21 тамирчин оролцож амжилттай зохион байгуулагдсан.



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Тал нутгийн марафон ОУ-н тэмцээн 2018.08.19-ны өдөр Төв аймгийн нутаг Шавартын Ам гэх газар амжилттай зохион байгуулагдсан. Төв аймгийн тамирчид амжилт арвинтай оролцлоо.



Дөрөв. Онцлох ба бүтээлч ажил

“Үндэсний цом-2018” 21 аймгийн хөлбөмбөгийн УАШТ 2018.08.17-25ны өдрүүдэд болсон ба тус тэмцээнд 16 байгууллагын 352 хүн хамруулан зохион байгуулалтанд идэвхитэй оролцон хамтран ажилласан.



Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

2018 ОНЫ 07-Р САРД ХИЙГДСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-07-31

Зуунмод

Нэг. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

2018 оны өсвөр үеийн софт теннисний улсын аварга шалгаруулах тэмцээн Зуунмод сумын шинээр баригдсан талбайд амжилттай болж 12 байгууллагын 120 тамирчин оролцлоо



Үндэсний спортын VI их наадмын хүрээнд зохион байгуулагдсан жороо морины уралдааны 2018 оны 07-р сарын 08-нд Батсүмбэр суманд зохион байгуулж 8 сумын 18 морь оролцсон



Ардын хувьсгалын 97, Төв аймаг байгуулагдсаны 95 жилийн ойн байр наадамд хүчит бөхийн барилдаанд улс аймгийн алдар цолтой 256 бөх, хүүхдийн барилдаанд 32 бөх барилдаж, үндэсний сурын харваанд 134 эрэгтэй, 58 эмэгтэй нийт 192 харваач, шагайн харваанд 20 сумын 24 багийн 172 харваач, хурдан морины уралдаанд 650 гаруй хурдани хүлэг тоосоо өгрөсөн.



“Төв түмний цэнгэл 2018” баяр наадмыг анх удаа Баянцогт суманд зохион явуулж сурын харваанд 30 харваач, шагайн харваанд 172 харваач, хурдан морины уралдаанд 352 нийт 650 хүн хамрагдсан.



Холбоочдын баярт зориулсан спортын баг наадмыг 2018.07.26-нд зохион явуулж 7 багийн 90 нгаруй тамирчидыг хамруулсан.



Уран уургач, бугуйлч, эмнэг булгиулагчдийн тэмцээнийг Алтанбулаг суманд 2018 оны 07-р сарын 25-нд зохион явуулж 10 сумын 65 адуучин оролцлоо



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Богд хан уулын Жаргалантын аманд орших "Чингисийн хүрээ" цогцолборт 2018-06-29-30-ны өдрүүдэд Граунд гольфийн Азийн аварга шалгаруулах тэмцээн болж амжилттай өндөрлөлөө. Аймгаасаа бид 10-уулаа оролцож 4 алтан бөмбөгтэй ирлээ. Багийн хамт олондоо баярлалаа.



Багануур дүүрэгт зохион байгуулагдсан үндэсний сурын багийн улсын аварга шалгаруулах тэмцээний 20 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцоод ирлээ.

Дөрөв. Бүтээлч ажил

Баяр наадам болохтой холбогдуулан төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна орчмын цэвэрлэгээ үйлчилгээг хийж аймгийн хөрөнгө оруулалтаар тохижилт үйлчилгээг хийсэн:



Аймгийн үндэсний спортын VI их наадмын сорилго, бүс, шигшээ тэмцээний хүрээнд 23 арга хэмжээ зохион байгуулж 27 сумын 2373 хүн оролцож үндэсний сурын талбай /69.5 сая/, шагайн харвааны асар (25мх30м) /269 сая/ төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулж ашиглалтанд оруулан үндэсний спортын талбай байгуулахад 338.5 сая төгрөг зарцуулсан.





Тайлан бичсэн
Нарийн бичиг Д.Энхцэцэг



2018 ОНЫ 06-Р САРД
ХИЙГДСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-07-02

Зуунмод

Нэг. Сургалт сурталчилгаа

Хэнтий аймагт зохион байгуулагдсан Биеийн тамир, спортын тухай хууль, эрх зүйн баримт бичгшүүд, биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах, бодлог, цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах нь сэдэвт 2 хоногийн сургалт семинарт дасгалжуулагч, арга зүйчид хамрагдлаа.



Хоёр. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Хүүхдийн эрхийн хамгаалах өдрөөр 13-14 насны тамирчдын дунд зохиогдсон 3x3 сагсан бөмбөгийн тэмцээнд охидын 8, хөвгүүдийн 12 багийн 78 тамирчин оролцсон



Аймгийн үндэсний спортын VI их наадмын шагайн харвааны аварга шалгаруулах тэмцээн 2018-06-02нд амжилттай болж 8 сумын 12 багийн 92 харваач оролцсоноос МУҮДМ 4, МУДМ-1, МУХМ-2, МУМ-3, ХМ-3, Аймгийн гоц мэргэн 22 харваач оролцсон.



Төрийн албан хаагчдын спортын анхдугаар наадмыг Эрдэнэ, Лүн, Баян-Өнжүүл, Баянчандмань, Угтаал, Зуунмод гэсэн 6 бүсэд зохион байгуулж шигшээ тэмцээнийг 2018.06.15-17-ны өдрүүдэд спортын 8 төрлөөр зохион байгуулж 4.098 хүнийг хамруулсан.



Аймгийн үндэсний спортын VI их наадмын хүрээнд сурын харвааг Үндэснийсур, Урианхай сур, Буриад сур гэсэн 3 төрлөөр 2018 оны 6-р сарын 8-9 зохион явуулж 5 сумын 60 гаруй тамирчид, ширээний шагайн 2018-06-09 нд зохиож 56 тамирчин оролцлоо.



“Шилдэг хос” шалгаруулах” цэнгээнт бүжгийн тэмцээнийг 2018.06.20-нд зохион явуулж 11 сумын 29 хос ба 58 бүжигчид хамрагдсан.



“Хөдөлгөөн эрүүл мэнд -2018” өдөрлөгийг 06-сарын 12-13 нд Заамар суманд Аймгийн Ахмадын хороотой хамтран зохион явуулж 9-н сумын 10-н багийн 230 тамирчин спортын 4-н төрлөөр өрсөлдсөн.



“Ланс-2018” Ланс уулыг гороолох явган аялалыг 2018.06.23-нд Аймгийн Дашчойнхорлон хийд, Аймгийн ахмадын хороотой хамтран зохион явуулж 5-н багийн 38 ахмад хамрагдсан.



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан өсвөр үеийн уулын дугуйн УАШТ-нд манай баг тамирчид амжилттай оролцож 4 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 1-р байр, Насанд хүрэгчдийн



Масс рестлингийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд орох эрх авах тэмцээн болж манай 3 Ганчулуун Билгүүн Банзаргч нар эрхээ авч Шилдэг тамирчны цом, 3 алт 2 мөнгө 2 хүрэл авчлаа.Багаараа тэргүүлэв



Тав. Бүтээлч ажил

Ардын хувьсгалын 97, аймаг байгуулагдсаны 95 жилийн ойн баяр наадмыг угтаж байгууллагын гадна өнгө үзэмжийг сайжруулах засвар үйлчилгээг хийж, ногоон байгууламжийг сэргээн цэцгийн мандар, зүлэгжүүлэлтийг сайжруулсан.



Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

2018 ОНЫ 05-Р САРД
ХИЙГДСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн пара спортын хөгжил сэдэвт сургалтын Аймгийн ХХҮГ-тай хамтран зохион байгуулж нийт 34 хүнийг хамруулсан.



Төв аймгийн Заамар суманд нийгмийн салбарын байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 147 хүн оролцсон. 1 а ангийн сурагчдын цүнхний жингийг судалгаанд авч 24-н сурагч хамрагдсанаас 4-н сурагч хэвийн 18-н сурагч илүү хүнд жинтэй цүнх үүрч байна. Цүнхийг яаж тохируулж үүрэх талаар биеийн тамирын багш, бага ангийн багш, эцэг эхчүүд, сурагчдад зөвлөмж өгч, гарын авлага тараах материал өгсөн.



Хоёр. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Төв аймгийн Дэлгэрхаан сумын харъяат МУ-ын Гавъяат тамирчин Ц.Шаравжамцын нэрэмжит 2018 оны өсвөр үеийн ААШ сагсан бөмбөгийн 9 дэх удаагийн тэмцээн 2018.04.28-29-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 18 сумын 23 байгууллагын 93 багийн 651 тамирчид хамрагдаж 3 насны ангилалаар өрсөлдлөө.



Төв аймгийн Цагдаагийн байгууллагын 75 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан МУ-ын ардын багш, гавъяат тамирчин, МУ-ын харцага, цагдаагийн бэлтгэл хошууч, Д.Сэрээтэрийн нэрэмжит цагдаа дотоодын цэргийн анги байгууллагуудын 2018 оны аварга шалгаруулах чөөөт бөхийн тэмцээн 2018.05.05-нд зохион байгуулагдаж 30 байгууллагын 218 тамирчин оролцлоо.



Төвийн бүсийн дулааны станцуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг нөхөрсөг тэмцээн 20 дах удаагаа Төв аймагт 2018.05.07-нд зохион байгуулагдаж 6 байгууллагын 108 тамирчин спортын 4 төрлөөр өрсөлдсөн.



Хөнгөн атлетикийн өсвөр үеийн 2018 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2018.05.05-06-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 11 сумын 15 байгууллагын 150 тамирчин оролцсон.



Цэрэг спортын олон төрөлтийн тэмцээнийг аймгийн цэргийн штабтай хамтран 2018-05-11-нд зохион байгуулж Алтанбулаг, Борнуур, Эрдэнэсант, ХЦСургууль, 4-р сургууль, 5-р сургуулийн 60 тамирчин оролцсон.



Татвар төлөгчдийн өдөр зориулсан албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн дунд Аймгийн Татварын Хэлтсээс 2018-05-11-12-нд зохион байгуулсан сагсан бөмбөгийн тэмцээнд эрэгтэй 16, эмэгтэй 9 багийн 163 тамирчин ороцлоо



Сумын цолтой буюу цолгүй залуу бөхчүүдийн барилдааныг Төв аймгийн Үндэсний бөхийн холбооноос зохион явуулж 12 аймаг, сумын 60 бөх оролцож хэнтийн аймгийн сумын заан Ө.Алтанцоож түрүүдэн, Сэлэнгэ аймгийн сумын заан Х.Наранбаяр үзүүрлэсэн



Эрүүл мэндийн салбарын ажилчдын спортын наадам 2018 оны 05-р сарын 21-22-нд өдрүүдэд зохион байгуулагдаж 7 багийн 100 гаруй тамирчид оролцлоо.

Прокурорын байгууллагын ажилтан албан хаагчдийн дунд зохиогдсон спортын бага наадмын Төвийн бүсийн тэмцээн 2018.05.24-нд зохион байгуулагдаж Дархан, Орхон, Сэлэнгэ, Төв аймгийн 4 багийн 70 гаруй тамирчид спортын 6 төрлөөр өрсөлдлөө.

Манлайн баярсаглант бөхитйн барилдааныг Архуст, Батсүмбэр сумд хамтран зохион байгуулж 32 бөх барилдсан.



Аймгийн ЗД-ын ивээл дор зохион байгуулагдсан цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн ААШТ-н 2018.05.25-нд зохион байгуулагдаж 29 цэцэрлэгийн 350 тамирчин оролцлоо.



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Сагсан бөмбөгийн Төв-Ургац клубын тамирчид Монголын сагсан бөмбөгийн холбооноос зохион байгуулагдсан ДЭЭД лигийн тэмцээний ДЭД байрыг эзэлсэн

Масрестленгийн УАШТ-нээс 90 кг-ын жинд атмирчин Б.Бат-Эрдэнэ алтан медаль хүртсэн.

Дөрөв. Онцлох ажил

Төрийн албан хаагчдын спортын анхдугаар их наадмын бүсийн тэмцээнийг Эрдэнэ, Баян-Өнжүүл, Лүн, Угтаал, Баянчандмань, Зуунмод сумдад зохион явуулж 26 сум, 31 байгууллагын 1.176 төрийн албан хаагчид оролцсон.



Тав. Бүтээлч ажил

Мод тарих өдрөөр байгууллагын хашаан дотор 26 мод шинээр суулгасан.



Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2018 ОНЫ 04-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-04-27

Зуунмод

Нэг. Сургалт сурталчилгаа

БТ-ын багш сурагчдын олимпиадыг 2018 оны 04- сарын 05-ны өдөр зохион байгуулж 21 сумын 34 багш, сурагчдын олимпиадад эрэгтэй 31, эмэгтэй 26 сурагч хамрагдан бие бялдар, онолоор өрсөлдлөө



БТ-ын багш нарын сургалт семинарыг 2018-04-06-нд БСУГ-ын хурлын танхимд зохион байгуулж 23 сумын 35 багш хамрагдан сургалтанд ТСБТСДуС-ийн захирал, доктор профессор /Ph.D Ч.Зоригтбаатар, ТСБТСДуС-ийн багш, магистр Х.Гэрэлцогт, Анагаах ухааны доктор профессор Аврага БТДС-ийн гүйцэтгэх захирал Г.Сүхбат, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-ын ахлах мэргэжилтэн Х.Отгонбаатар, Сөүл олимпын зөвлөлийн дарга Ц.Чанцал, БСУГ-ын мэргэжилтэн Ч.Цэцгээ нар оролцож хичээл заалаа.



Алтанбулаг суманд зохион байгуулагдсан нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр багуудын ИНХ-д оролцон зургаан байгуулагад ажлын байрны дасгалын плакат, гарын авлага, тараах материалыг, ЕБС-д чөлөөт бөхийн дасгалжуулалт, спортын сэтгэл зүй, үндэсний бөхийн тухай нийт таван номыг өгч, сорил авах аргачлал, биеийн жингийн индексийг гаргах талаар заавар зөвлөгөөг өгсөн.



Хоёр. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Төв аймгийн Алтанбулаг сумын харъяат Ази тивийн аварга, ОУХМ, улсын заан Рөнцэнхүүгийн Гансүхийн нэрэмжит бөхийн чөлөөт барилдааны 2018 оны залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн 2018-04-07-08-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 10 аймгийн 4 дүүргийн 30 багийн 350 гаруй тамирчид оролцсон



Зуунмод сумын ЕБС-ын дунд сурагчдын сагсан бөмбөгийн лигийн аварга шалгаруулах тэмцээнийг 1 сарын хугацаанд зохион явуулж 114 сурагч оролцон шигшээ тоглолтыг 201.04.13-нд зохион байгууллаа.



НБТ-ийн чиглэлээр зохион байгуулагддаг Нарны алхааг 2018.04.11-ны өдрөөс эхлэн зохион байгуулж 4-р сард 3 удаа зохион явуулд байгууллагын хүнийг хамруулсан



2018 шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018.04.14-15-нд зохион байгуулж 15 аймаг 30 багийн 250 харваач оролцлоо.



Монголын үндэсний олимпийн хорооноос олимпийн хөдөлгөөнийг сурталчлан дэлгэрүүлэх, сурагчдын олимпийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг 21 аймаг 9 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зарлан явуулсан билээн.Энэ аяны хүрээнд манай аймаг Олимпийн медалуудыг сум, сургуулиудаар аялуулж 27 сум 97 баг, 31 сургуулиудаар аялаж 20 мянган хүнд хүрч ажиллаа.



Гүрав. Оролцсон уралдаан тэмцээн

Завхан аймгийн Улиастай хотод зохиогдсон Самбо бөхийн Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд нийт 21 аймгийн 25 байгуулгын 500 гаруй тамирчид оролцож. тамирчин Д.Номинзул +75 кг жинд Мөнгөн медаль, Самбо бөхийн Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд нийт 25 байгуулгын 250 гаруй тамирчид оролцож тамирчин Д.Номинзул +75 кг жинд Мөнгөн медаль хүртлээ



Жүдо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн Дархан Уул аймагт болж 5 аймгийн 300 гаруй тамирчид оролцсоноос манай баг тамирчид 1 алт, 3 мөнгө, 4 хүрэл медаль хүртлээ.



Байт харвааны заалны 2018 оны улсын аварга шалгаруулах тэмцээн 04-р сарын 01-нд зохион байгуулагдаж 12 байгууллагын 187 тамирчин оролцсоноос манай өсвөрийн шигшээ багийн тамирчид 2 алт, 6 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр эзэллээ.



Дөрөв. Онцлох ажил

Төв аймгийн Алтанбулаг сумын харъяат Ази тивийн аварга, ОУХМ, улсын заан Рөнцэнхүүгийн Гансүхийн нэрэмжит бөхийн чөлөөт барилдааны 2018 оны залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн 2018-04-07-08-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 10 аймгийн 4 дүүргийн 30 багийн 350 гаруй тамирчид оролцсон



“Хөгжил-Хөдөлгөөн-Эрүүл мэнд-2018” удирдах ажилтнуудын тэмцээн сүүлийн 2 жил тасраад байсныг 2018-04-20-21-ны өдрүүдэд зохион явуулж 8 багийн 88 хүнийг хамруулсан.



Заамар сумын нэрэмжит 2018 оны өсвөрийн волейболчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2018-04-21-22-ны өдрүүдэд Заамар суманд зохион байгуулагдаж хөвгүүдийн 8, охидын 7 нийт 5 сумын 88 тамирчин оролцлоо.

Тав. Бүтээлч ажил

Байгууллагаас гарч буй хог хаягдлыг төрөлжүүлэн хаях хогийн савыг шинээр хийж байрлууллаа.



Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2018 ОНЫ 03-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-03-28

Зуунмод

Нэг. Дотоод зохион байгуулалтын талаар

Багш ажилчдын 1-р улирлын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, цаашид шаардлагатай ажилуудыг хэлэлцэн тохиролцож, 2-р улирлыг ажлын төлөвлөгөөг батлан гаргалаа.

Хоёр. Сургалт сурталчилгаа

ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагаас зохион байгуулсан БТСГ-ын арга зүйчид, клуб, хамтлагийн гишүүдийн сургалт семинарт арга зүйч Л.Хишигдэлгэр, Баянчандмань сумын НБТ-ын арга зүйч А.Билгүүн, шилдэг жү-до клубын дасгалжуулагч Ц.Батзаяа нар хамрагдлаа.



2018-03-14-нд АЗДТГ-ын ХЗХ-ээс зохион байгуулагдсан авлига, ашиг сонирхолын зөрчил, ёс зүйн сэдвээр зохион байгуулагдсан сургалтанд арга зүйч Б.Золжаргал, Х.Амар, нарийн бичиг Д.Энхцэцэг нар хамрагдлаа

Гурав. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Аймгийн аварга шалгаруулах Зуунбуудалт даамын тэмцээнийг 2018 оны 03-р сарын 03-04-ны өдрүүдэд зохион явуулж 8-н сум сургуулийн 130 н өсвөрийн тамирчин хүүхэд, насанд хүрэгчид 26-н тамирчинд оролцсон



Төв Зуунмод Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн ажилчин албан хаагчдын дундах тэмцээнийг 2018-03-07-ны өдөр спортын 4 төрлөөр зохион явуулж 5 багийн 40 гаруй хүн хамрагдсан.

Энх мэндийн харваа 2018 шагайн харвааны тэмцээнийг 2018-03-10-11 зохион байгуулж 11 аймаг 4 дүүргийн 72 багийн 645 харваач оролцлоо.



Зэвсэгт хүчний 97, Монгол цэргийн баярт зориулсан хүчит 64 бөхийн барилдааныг 2018-03-16-нд зохион явуулсан.



БТСГазар, Ахмадын хороо, Батсүмбэр сумын ахмадын хороотой хамтран ахмадуудын дунд дуу, бүжгийн цэнгүүн өдөрлөгийг 2018-03-15-ны өдөр Батсүмбэр суманд зохион байгууллаа. Өдөрлөгийн ажиллагаанд тус сумын 4 багын 120 гаруй ахмадууд оролцсон.



МУ-ын гавьяат дасгалжуулагч, улсын арслан Л.Сосорбарамын нэрэмжит жү-до, МУ-ын гавьяат тамирчин Г.Үүрцолмонгийн нэрэмжит самбо бөхийн өсвөр үеийн ААШТ-ийг 2018-03-17-18-ны өдрүүдэд зохион явуулж 16 сумын 330 гаруй тамирчид оролцлоо.



Дөрөв. Оролцсон уралдаан тэмцээн

Жү-до бөхийн Залуучуудын УАШТ-нд амжилттай оролцож тамирчин Д.Номинзул мөнгөн медаль хүртсэн. Мөн Жү-до сурагч 2018 сурагчдын аварга шалгаруулах тэмцээнээс ХЦС-ийн сурагч Ц.Буянжаргал + 70 кг-д мөнгөн медаль хүртлээ.



100-н буудалт даамны өсвөр үеийн УАШТ-н 2018-03-12-нд УБ хотод болж Жаргалант сумын сурагч А.Мөнхжаргал ОУ-ын тэмцээнд оролцох эрх авч, тамирчин А.Оюунгэрэл СДМ-ын болзол биелүүлэн. 2 тамирчин 1-р зэрэг, 2 тамирчин 3-р зэргийн болзол биелүүлсэн

Чөлөөт бөхийн өсвөр үеийн УАШТ-н 2018-03-17-18-ны өдрүүдэд УБ хотноо зохион байгуулагдан 41 байгууллагын 690 гаруй тамирчид өрсөлдсөнөөс манай 22 тамирчинтай баг амжилттай оролцож 1 алт, 2 хүрэл медаль хүртэж 5 тамирчин шагналт 5-р байрт шалгаран багийн дүнгээр 4-р байрыг эзэллээ.



Ширээний теннисний өсвөр үеийн УАШТ 2018-03-20-24-нд зохион байгуулагдаж манай 24 тамирчин оролцоноос Угтаалцайдам сумын тамирчин Оюунханд хүрэл медаль хүртэж 16 тамирчин зооноосоо гарч хагас шигшээд толглосон

Тав. Онцлох ажил

2018-03-08-11-ны өдрүүдэд Төв аймгийн Жаргалант суманд насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах цанын тэмцээн болж 10 байгууллагын 30 гаруй тамирчид оролцож хүрд хүчээ сорин өрсөлдсөнөөс манай аймгийн өсвөрийн баг тамирчид 2 мөнгөн медаль хүртэж Жаргалант сумын тамирчин Б.Хонгор спортын мастер, Борнуур сумын тамирчин Д.Урангоо, С.Энхболд нар спортын мастериин болзлыг биелүүлсэн амжилтыг үзүүллээ.



Зургаа. Бүтээлч ажил

2018-03-22 –ны өдөр бүх нийтийн цэвэрлэгээг хийж байгууллага орчны болон төв цэнгэлдэх хүрээлэнгийн хог хаягдлыг цэвэрлэх ажилд 11 хүнийг хамруулан 50 шуудай хогийг захирагчийн албанд мэдэгдэж хот тохижуулахийн хогийн машинд ачуулсан.



Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2018 ОНЫ 02-Р САРД
ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-02-27

Зуунмод

Нэг. Дотоод зохион байгуулалтын талаар

Цагаан сарын баярыг угтан байгууллагын дотоно гадна их цэвэрлэгээг хийж, байгууллагын гадна 50 м орчмын цасыг цэвэрлэхэд 16 хүн хамрагдсан..

Хоёр.Сургалт сурталчилгаа

Жү-до бөхийн шинэ дүрмийн талаарх сургалтанд дасгалжуулагч Ц.Батзаяа хамрагдсан.



Гурав. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

АБТА, БТТА СМ Л.Нямцэрэнгийн нэрэмжит аймгийн аварга шалгаруулах тэшүүрийн тэмцээн 2018-01-31-нд Төв аймгийн Алтанбулаг суманд зохион байгуулагдан 2 сумын 30 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.



Цагаан сарын баяр болохтой холбогдуулан Аймгийн Цагдаагийн газраас дээлтэй Монгол өдөрлөг болж 64 бөхийн барилдааныг зохион явууллаа.




2018 оны өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн ААШТ-н 2018.02.03-04-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдан 14 сумын 19 байгууллагын өсвөр үе 231, залуучууд насанд хүрэгчид 40 тамирчин оюун ухаанаа сорин өрсөлдсөн



МУ-ын гавъяат дасгалжуулагч, улсын арслан Ө.Эрдэнэ-Очирын нэрэмжит өсвөр үеийн чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2018-02-09-10-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 14 сумын 17 байгууллагын 230 гаруй тамирчид хөвгүүд 12, охид 8 жинд, МУ-ын гавъяат тамирчин, ардын багш, улсын харцага, олимпийн наадмын хүрэл медальт Д.Сэрээтэрийн нэрэмжит залуучуудын чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2018-02-11-ны өдөр зохион байгуулагдаж 14 сумын 80 гаруй тамирчид хөвгүүд 5, охид 5 жинд хүч чадлаа сорин өрсөлдлөө.



“Жаргалант-2018” өсвөрийн цанычдын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 02-р сарын 22-25-ны өдрүүдэд Төв аймгийн Жаргалант суманд зохион байгуулагдаж 12 аймаг, 2 дүүргийн 20 багийн 164 тамирчин оролцож 96 багц медалын төлөө өрсөлдлөө. Манай баг тамирчид 13 алт, 7 мөнгө, 2 хүрэл медаль, багийн дүнгээр алт нийт 23 медаль хүртэж 1 спортын мастер төрөн гарлаа.



Баянчандмань сумын нэрэмжит ширээний теннисний ААШТ 2018-02-24-25-ны өдрүүдэд Баянчандмань суманд болж Баянчандмань, Батсүмбэр, Жаргалнат, Угтаалцайдам, ХЦС, 5-р сургуулийн 119 тамирчид оролцлоо.



Эх орончдын өдөрт зориулсан сагсан бөмбөгийн тэмцээн 2018-02-24-25-нд зохион байгуулагдаж 10 сумын 36 багийн 312 тамирчин оролцсон.



Хоёр. Оролцсон уралдаан тэмцээн

Оддын гараа чөлөөт бөхийн олон хотын тэмцээн 2018.02.03-04-нд Налайх хотод зохион байгуулагдаж манай баг тамирчид амжилттай оролцон 1 алт, 2 хүрэл медаль хүртлээ

Залуучуудын УАШ жү-до бөхийн тэмцээн 02-р сарын 03-04-нд УБ хотод болж манай баг тамирчид амжилттай оролцож тамирчин Номнизул мөнгөн медаль хүртлээ. Мөн 02-р сарын 22-24-нд зохиогдсон кураш бөхийн УАШТ-нээс Ц.Буянжаргал мөнгөн медаль хүртсэн.



Гүйлтийн тэшүүрийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 02-р сарын 24-25-нд Зохион байгуулагдаж 12 алт, 4 мөнгө, 4 хүрэл нийт 20 медаль хүртэж багийн дүнгээр 1-р байр эзэллээ. Тамирчин М.Сувд-Эрдэнэ 300 м-ын зайд 37,80 гүйж улсын рекорд дээд амжилтыг эвдсэн



Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээн мөсний сур, мөсний шагайн харвааны наадмуудад манай баг тамирчид амжилттай оролцлоо.



Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2018 ОНЫ 01-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2018-01-29

Зуунмод

Нэг. Дотоод зохион байгуулалтын талаар

Бүх ажилчидтай хөдөлийн гэрээг байгуулах бэлтгэл ажлыг ханган багш дасгалжуулагчид ажилчид жил улирлын ажлын төлөвлөгөө, секц дугуйлангийн төлөвлөгөө, хуваарийг батлуулан ажиллаж байна.

2018 оны уралдаан тэмцээний нэгдсэн заавар удирдамжийг батлан сумдад хүргүүлэхэд бэлэн болгосон.

Хоёр. Сургалт сурталчилгаа

Хөдөлмөрийн хууль тогтоомжийг сурталчилах, аяны хүрээнд МТТеатр, Музей, Номын сан, БТСГ-ын Газар хамтран хуулчдын зөвлөлийн тэргүүн Б.Баярмагнайгаар хөдөлмөрийн тухай хууль, зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгуулж манай байгууллагын 14 хүн хамрагдсан.



Сагсан бөмбөгийн багш багш дасгалжуулагчдын сургалт семинар 2018-01-22-26-ны өдрүүдэд Орхон аймагт болж дасгалжуулагч Д.эрдэнэбаатар хамрагдлаа.



Гурав. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Зуунмодны хүчтэн пауэрлифтингийн тэмцээнийг 2018-01-6-7-ны өдрүүдэд зохион байгуулж 8 байгууллагын 80 гаруй тамирчид оролцсон.



Үндсэн хуулийн өдөрт зориулсан үндэсний бөхийн барилдааныг 2018-01-12-нд зохион байгуулж 32 бөх барилдлаа.



Төв, Налайх, Говьсүмбэр аймгуудын шүүхийн байгууллагуудын ажилчдын спортын наадам спортын 5 төрлөөр зохион байгуулагдсан.



Зуунмод сумын ЗДТГ-ын ажилчид, ИТХ-ын тэргүүлэгчдийн дунд зохиогдсон спортын 5-н төрөлт тэмцээн 2018-01-р сарын 20-нд зохион байгуулагдан 8 багийн 120 хүн хамрагдаж тэмцээний нээлтийн ажиллагаан дээр бүх хүн ажлын байрны дасгалыг хийснээр тэмцээний онцлог байлаа.



Олимпзм ба бие бялдрын хүмүүжил сэдэвт болзолт уралдааны хүнээннд зохион байгуулагдаж буй Төв нутгийн олимпийн медальтнуудын бахархал аяны нээлтийн ажиллагааг 2018-01-25-ны

өдөр зохион байгуулж 150 гаруй сурагчид хамрагдан Алтанбулаг, Баянчандмань, Зуунмод, Эрдэнэ сумдад сумдаар аялах, медаль, дэвтрийг гардуулан өглөө.



Хоёр. Оролцсон уралдаан тэмцээн

Хорон аймагт болсон насанд хүрэгчдийн чөлөөт бөхийн тэмцээнд 28 байгууллагын 400 гаруй тамирчид оролцсоноос манай тамирчин Б.Даваацэрэн хүрэл медаль хүртсэн

Насанд хүрэгчдийн үндэсний лигийн тэмцээнд төв “Ургац” багамжилттай оролцож шилдэг 4-т шалгарсан. мөн өсвөрийн U-16 MNBA-ийн тэмцээнд амжилттай оролцож шигшээ 8-д шалгаран тамирчин Б.Шинэбаяр, Д.тэргэл, Б.наранбаяр нар улсын шигшээ багт тоглохоор болсон.



Төв аймгийн Заамар суманд 2017-01-27-28-нд болсон төвийн бүсийн аварга шалгаруулах цаны тэмцээнд манай баг тамирчид 4 алт, 9 мөнгө, 2 хүрэл бүгд 15 медаль хүртэж багийн дүнгээр 2-р байр эзэллээ.



Хэвтээ шахалтын улсын аварга шалгаруулах тэмцээн 2018-01-27-28-ны өдрүүдэд УБ хотноо зохион байгуулагдаж манай тамирчид 1 алт, 4 мөнгөн медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр эзэллээ.



Жюү Жицү бөхийн 2018 оны улсын аварга шалгаруулах тэмцээн 2018-01-05-07-нд УБ хотод болж тамирчин Ц.Буянжаргал 82 кг-ын жинд алт, Жюү Жицү бөхийн Азийн АШТ 2018-01-28-29-ны өдрүүдэд болж 63 кг-ын жинд тамирчин А.Норовсүрэн мөнгөн медаль хүртлээ.

**Төв аймгийн БТС-ын газар бүх нийтийн цэвэрлэгээнд оролцсон
тухай илтгэх хуудас**

2018-03-22

Зуунмод

Аймгийн БТС-ын газар 2018 оны 3-р сарын 22 –ны өдрийн 14:00 цагаас бүх нийтийн цэвэрлэгээнд ажилтан албан хаагчдаа зохион байгуулалт сайтай оролцуулж, ажлын шаардлагатай багаж хэрэгслээр өөрсдийн нөөц бололцоогоор хангаж,байгууллагынхаа орчин тойрны 50 метр хүртэлх талбай буюу соёл амралтын хүрээлэнгийн хашаа доторх явган зам, авто машины зам,нийтийн эзэмшлийн хог хаягдлыг бүрэн гүйцэд цэвэрлэж дууслаа.



Их цэвэрлэгээнд аймгийн БТС-ын газрын нийт 20 ажилчин албан хаагчдаас 13 хүн оролцож БТС-ын газарийн эргэн тойрон 50 метр хүртэлх талбай ,соёл амралтын хүрээлэнгий хашаан доторх болон эргэн тойронд их цэвэрлэгээг хийж ачиж зайлуулсан болно.

Илтгэх хуудас гаргасан БТС-ын

Өнөөдөр амьдралын минь бас нэгэн түүхэн өдөр байлаа. Аав ээж хэмээх эрхэм алдрыг хайрласан амин хайртай охин минь их сургуулиа амжилттай дүүргэж ромбо дипломоог ардан авч 4 жил мөр зэрэгцэн суралцаж, ижил дасал болсон ангийн нөхөдтэйгээ төгсөлтийн баяраа тэмдэглэлээ. Хайртай охиндоо хойшдын ажил амьдрал нь үргэлж гэгээн сайхан байж, эрүүл энх, эрч хүчтэй, ухаан төгс, урам зоригтой урагшлан дэвшиж удам угсаа аав ээжийнхээ нэрийг өндөрт өргөж эзэмшсэн мэрэгжилдээ эзэн болж эх орондоо хэрэгтэй чадварлаг боловсон хүчин болж аз жаргал, амжилт бүтээлээр алхам тутамдаа бялхаж явахыг хүсэн ерөөе! Хайртай шүү!

НАРНЫ АЛХАЛТ

Хүн бүр эрүүл амьдрах эрхтэй хэмээн хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан байдаг. Автомашин, техник технологи хөгжиж буй өнөө үед нийгэм тэр чигээрээ автомат горимд шилжсэн гэхэд хилсдэхгүй. Энэ бүхнээс шалтгаалан хүний биеийн хөдөлгөөн багасаж, элдэв өвчлөлийн суурь болох болсон. Тэгвэл өнгөрсөн 2017 онд аймгийн Засаг даргаас санаачлан 7 хоног бүрийн Лхагва гаригийг “Нийгмийн эрүүл мэндийн өдөр” болгож, нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах захирамж гаргасан юм. Уг захирамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчид болон иргэдийг хамарсан, тэдний эрүүл мэндийн боловсролд чиглэгдсэн, эрүүл мэндээ хамгаалах, дасгал хөдөлгөөн идэвхтэй хийх зэрэг биеийн тамир, спортын үйл ажиллагааг нь дэмжих “Нарны алхалт”-ыг зохион байгуулж эхэлсэн. Тус арга хэмжээ хүйтний улирал эхлэсэнтэй холбогдуулан хэсэг хугацаанд завсарлаад байсан бол энэ оны үйл ажиллагаа өнөөдөр 27 суманд зэрэг нээлтээ хийлээ. Өнгөрсөн 2017 онд 24 удаагийн алхалтыг хийсэн бөгөөд энэ хугацаанд Зуунмод сумын 62 аж ахуйн нэгж, байгууллагын 5500 орчим иргэд, 26 сумын 4300 гаруй иргэдийг хамруулсан бөгөөд Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 10 мянга орчим иргэн алхжээ.

“Нийгмийн эрүүл мэндийн өдөр”-ийг зохион байгуулсны үр дүнд Эрүүл мэндийн салбарт эерэг өөрчлөлтүүд гарч эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 10 хувиар буурсан бөгөөд үүнээс харахад уг арга хэмжээнд иргэд, олон нийт чухал ач холбогдол өгч, дасгал сургуулилтыг тогтмол хийж, амьдралдаа хэвшил болгож буйн илрэл юм.



Нэгэнт иргэдийн амьдралд бий болсон уг зөв дадал зуршлыг дэмжих үүднээс Аймгийн Засаг даргын зүгээс хөрөнгө оруулалтын арга хэмжээг цаг тухай бүрт нь шийдвэрлэж өгснөөр иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж бүхий хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбайг байгуулж, мөн хүүхдийн тоглоомын талбай бүхий соёл амралтын хүрээлэнг тохижуулсан

бөгөөд энэ онд эдгээр бүтээн байгуулалтуудыг улам боловсронгуй болгож, сайжруулах тал дээр ач холбогдол өгч ажиллах болно гэдгээ энэ үеэр хэлж байлаа.